



**ХАН-УУЛ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2025 оны 03 сарын 19 өдөр

Дугаар 01/185

Улаанбаатар хот

Энгийн болон тусгай зөвшөөрөл олгох, сунгах,
түдгэлзүүлэх, хүчингүй болгох, сэргээх үүрэг
бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэн
батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 62 дугаар зүйлийн 62.1.1, Зөвшөөрлийн тухай хуулийн 3.3 дугаар зүйлийн 3.3.2, 8.1 дүгээр зүйлийн 12.13, 8.2 дугаар зүйлийн 11.6 дахь заалт, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 15 дугаар зүйл, Тамхины хяналтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.9, 7.10, 7.11 дэх заалт, Нийслэлийн Засаг даргын "Эрх шилжүүлэх тухай" 2024 оны А/219 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүргийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл, тамхи худалдах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох, сэргээх асуудлаар дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажлын хэсгийн ажиллах журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Дүүргийн менежер (Ц.Эрдэнэбаатар)-т даалгасугай.


3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Хан-Уул дүүргийн Засаг даргын 2024 оны А/460 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ЦЭРЭН

1725010523

Хан-Уул дүүргийн Засаг даргын
2025 оны 03... дугаар... сарын
... өдрийн ... дугаар
захирамжийн 1 дүгээр хавсралт



ЭНГИЙН БОЛОН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ, СУНГАХ, ТҮДГЭЛЗҮҮЛЭХ,
ХҮЧИНГҮЙ БОЛГОХ, СЭРГЭЭХ ҮҮРЭГ БҮХИЙ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга:

Дүүргийн Менежер

Гишүүд:

Хүнс, худалдаа үйлчилгээний
хэлтсийн дарга

Санхүү, төрийн сангийн
хэлтсийн дарга

Тохижилт, нийтийн аж ахуйн
хэлтсийн дарга

Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Хан-Уул дүүргийн Цагдаагийн
газрын дарга

Хан-Уул дүүргийн Татварын
хэлтсийн дарга

Хан-Уул дүүргийн Улсын
бүртгэлийн хэлтсийн дарга

Хан-Уул дүүргийн Онцгой
байдлын хэлтсийн дарга

Нийслэлийн Хүнс, хөдөө аж
ахуйн газрын улсын ахлах
байцаагч

Нийслэлийн Эрүүл мэндийн
газрын улсын ахлах байцаагч

Нарийн бичиг:

Хүнс, худалдаа үйлчилгээний
хэлтсийн Худалдаа, ахуйн
үйлчилгээ хариуцсан
мэргэжилтэн П.Баяржаргал,
А.Хишигсайхан

Хан-Уул дүүргийн Засаг даргын
2025 оны 03... сарын
19... өдрийн... захирамжийн 2 дугаар хавсралт

ЭНГИЙН БОЛОН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ, СУНГАХ, ТҮДГЭЛЗҮҮЛЭХ,
ХҮЧИНГҮЙ БОЛГОХ, СЭРГЭЭХ ҮҮРЭГ БҮХИЙ АЖЛЫН ХЭСГИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл, тамхи худалдах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл шинээр олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох, сэргээх асуудлаар дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг нь Зөвшөөрлийн тухай хууль, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Тамхины хяналтын тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, дүрэм, журмыг баримтална.

Хоёр. Ажлын хэсгийн ажиллах зарчим

2.1. Ажлын хэсэг дараах асуудлыг хэлэлцэж дүгнэлт гаргана.

2.1.1. Дүүргийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл, тамхи худалдах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг шинээр олгох;

2.1.2. Тусгай болон энгийн зөвшөөрлийн хугацааг сунгах;

2.1.3. Тусгай болон энгийн зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх;

2.1.4. Тусгай болон энгийн зөвшөөрлийг хүчингүй болгох;

2.1.5. Тусгай болон энгийн зөвшөөрлийн хаягийн өөрчлөлт, аж ахуйн нэгжийн нэр, захирлын нэр өөрчлөх;

2.2. Ажлын хэсэг баримт бичгийн бүрдлийг магадлан шалгах ажиллагааг Зөвшөөрлийн тухай хуулийн 5.2 дугаар зүйлд заасны дагуу шийдвэрлэнэ.

2.3. Ажлын хэсэг магадлан шалгах хугацааг дууссанаас хойш ажлын 3 өдөрт багтаан хуралдах бөгөөд хурлыг танхимаар болон цахимаар зохион байгуулж, зөвшөөрөл олгох эсэх шийдвэр гаргана.

2.4. Ажлын хэсгийн гишүүдийн гуравны хоёр нь оролцсоноор хурлыг хүчинтэйд тооцно. Хуралд ажлын хэсгийн нарийн бичгийн дарга саналын эрхгүй оролцох бөгөөд ажлын хэсгийн бэлтгэл ажил, зохион байгуулалтыг хариуцан ажиллана.

2.5. Ажлын хэсгийн хурлыг дарга удирдах бөгөөд түүний эзгүйд Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга удирдана.

Гурав. Ажлын хэсгийн хурлын бэлтгэл ажлыг хангах, магадлан шалгах, зохион байгуулах



3.1.Төрийн үйлчилгээний <https://e-business.mn/home> цахим системд ирүүлсэн тамхи худалдах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хүсэлт, нийслэлийн мэдээ мэдээллийн <https://ulaanbaatar.mn/home> цахим хуудасны "Үйлчилгээ эрхлэх бүртгэлийн систем"-ээр ирүүлсэн согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийн хүсэлтийг Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтсийн Худалдаа, ахуйн үйлчилгээ, Хоол үйлдвэрлэл, аялал жуулчлал хариуцсан мэргэжилтнүүд хүлээн авч, баримт бичгийн бүрдлийг магадлан шалгасны дараа жагсаалтыг гарган, танилцуулгыг бэлтгэнэ. Ажлын хэсгийн нарийн бичиг магадлан шалгасан иргэн, хуулийн этгээдийн нэрсийн жагсаалтыг гишүүдэд хурал болохоос ажлын 3 өдрийн өмнө хүргүүлнэ.

3.2.Ажлын хэсгийн гишүүд жагсаалт, мэдээлэлтэй танилцан хянан баталгаажуулж, зөвшөөрөл олгох эсэх дүгнэлтэд санал өгнө.

3.3.Ажлын хэсгийн нарийн бичиг магадлан шалгагдсан мэдээллийг жагсаалтын дагуу хуралд танилцуулж, гишүүдийн саналыг авч, хурлын тэмдэглэлд тусгана.

3.4.Хуралд оролцох боломжгүй гишүүн саналаа бичгээр гарган, гарын үсэг зурж баталгаажуулан, ажлын хэсгийн нарийн бичигт хурал болохоос 1 өдрийн өмнө ирүүлнэ. Шаардлагатай тохиолдолд даргын зөвшөөрлөөр орлох албан тушаалтныг хуралд оролцуулна.

Дөрөв. Шийдвэр гаргах

4.1.Хуралд оролцсон ажлын хэсгийн гишүүд хурлын тэмдэглэлд гарын үсэг зурж, баталгаажуулах бөгөөд оролцсон гишүүдийн гуравны хоёрын саналаар дэмжсэн эсхүл татгалзсан тухай дүгнэлт гаргана.

4.2.Ажлын хэсгийн нарийн бичиг хурлын тэмдэглэл, захирамжийн төслийг дүүргийн Засаг даргад хүргүүлж, Зөвшөөрлийн тухай хуулийн 5.2 дугаар зүйлд заасан хугацаанд шийдвэр гаргуулна.

4.3.Ажлын хэсгийн нарийн бичиг гишүүдийн санал дүгнэлтийн дагуу татгалзсан эсхүл хүчингүй болгосон тухай хариуг хүсэлт гаргасан иргэн, хуулийн этгээдэд бичгээр хүргүүлнэ.